



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 8/18

Сүмбэр сум

Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан албан хаагчдын гэр бүл, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар санал санаачлага гарган ажиллах чиг үүрэг бүхий зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

|         |               |
|---------|---------------|
| Дарга:  | Л.Эрдэнэчимэг |
| Гишүүн: | Э.Цэлмэгбаяр  |
|         | Б.Аззаяа      |

2. Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр, хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, жил бүрийн батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан, тайланг бүтэн жилээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн ажиллахыг зөвлөлийн дарга (Л.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.АЛТАНЦЭЦЭГ